



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 23

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 1,452,000 (Нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянга) төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй олон үйлдэлт орыг Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэгт үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн газрын дарга (Б.Алтантөгс), Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн дарга (Х.Чирчинсүрэн) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Шилжүүлэх хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.МӨНХЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн  
23 дугаар тогтоолын хавсралт

Эрүүл мэндийн газрын балансаас балансад  
шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

| №        | Хөрөнгийн нэр   | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо | Балансын үнэ  | Хуримтлагдсан элэгдэл                                   | Үлдэгдэл өртөг  | Шилжүүлэн авах байгууллага               |
|----------|-----------------|------------------------|-------------|-----|---|---|-----------------|--|
| 1        | Олон үйлдэлт ор | 2018-09-30             | ш           | 1   | 1,452,000   | 1,452,000   | 0               | Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг |
| Нийт дүн |                 |                        |             | 1   | 1,452,000 /нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянга/ төгрөг | 1,452,000 /нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянга/ төгрөг | 0 /тэг / төгрөг |  |